



МОНГОЛ ХҮҮХДҮҮДИЙН ТУХАЙ МИНИЙ СЭТГЭГДЭЛ

*Монгол – Энэтхэгийн хамтарсан сургуулийн
англи хэлний багш Читра Хант*

Би Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуульд англи хэлний багшаар ирж ажилласнаас хойш эдүгээ 4 жил өнгөрчээ. Энэтхэгийн Засгийн газраас англи хэлний багш хатагтай Chitra Hunt, ноён Shenbaga Nathan, Deshai Reddy, математикийн багш ноён M.SriniVasan, компьютерийн багш ноён Biswal нарыг Монгол - Энэтхэгийн хамтарсан сургуульд багшлуулахаар томилсон билээ. Бид Энэтхэг улсын нийслэл New Delhi дэх Kendriya Vidyalaya Sangathan байгууллагаас томилогдон багаар ажиллаж байна.

Бидний гол зорилго бол монгол сурагчдад англи хэл, компьютер, математикийн өргөн цар хүрээтэй мэдлэг олгох явдал юм.

8-11-р ангийн сурагчид англи хэлний хичээлээр анхан ба гүнзгий шатны 2 бүлэгт хуваагддаг. Энэ нь сурагч нэг бүртэй бие даан ажиллахад дөхөм болдог. Сурагчид англи хэлний дүрмийн мэдлэгтэй ч англиар чөлөөтэй харьцаж чаддаггүйн улмаас тэдний ярианы чадварыг сайжруулахын тулд багш нар сурагчидтайгаа байнга ярианы даллага хийх шаардлагатай байдаг. Сурагчид ярих, бичих, унших чадвараа байнга хөгжүүлж, хэлний дүрэм, зүй тогтлыг эзэмшихийн тулд хичээлээр мэдсэн сурснаа өдөр тутам хэрэглэж байх нь чухал. Англи хэлний олимпиад, Англи хэлний нээлттэй өдөр, бусад тэмцээн уралдааныг зохион байгуулснаар сурагчдын оролцоог идэвхжүүлэх, англи хэлийг шангралгүйгээр судлах боломж нэмэгдэж байна. Сурагчид математикийн англи нэр томъёог судалж мэдсэнээр хэлний бэрхшээлээ төвөггүйхэн шийдвэрлэж, англиар ойлгох чадвартай боллоо. Монгол сурагчид болон энэтхэг багш нар хамтран ажиллаж чадсанаар илүү үр дүнд хүрч байгаа. Энэ дөрвөн жилийн хугацаа нь бидэнд мэргэжлийн хувьд ахиж дэвших нөхцөл боломжийг бүрдүүлсэн бөгөөд хичээл сургалтанд ашиглаж буй үзүүлэн таниулах материал нь хэлний кабинетэд хичээллэх таатай орчныг бий болгож, сурагчдыг тухайн хичээлд идэвхтэй оролцох боломжийг олгож байна.

Тэрчлэн сургуулийн удирдлагын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа нь бидэнд ажиллах урам зоригийг өгч байдгийг дурдах нь зүйтэй. Монгол сурагчид шинэ зүйлийг сурч мэдэхдээ тун авхаалжтай. Тавьсан зорилгодоо хүрэхээр мэрийх өрсөлдөх чадварыг эзэмшсэн манай сурагчид багаар хамтран ажиллахдаа их сайн. Үүний зэрэгцээ Монгол - Энэтхэгийн хоорондын соёлын солилцоо нь сурагчдыг сургуулиас зохион байгуулсан соёлын арга хэмжээнд идэвхтэй оролцоход түлхэц болдог. Энэ нь хоёр орны хоорондын соёлын ялгааг үнэлэх үнэлэмж, ухамсрыг төлөвшүүлдэг. Монгол сурагчдад өргөн цар

хүрээтэй мэдлэг хүртэх боломж олгож буй Энэтхэг оронд манай төгсөгчид үргэлжүүлэн суралцаж дээд боловсролтой болох сонирхолтой байдаг.

Эцэст нь хэлэхэд, Монгол - Энэтхэгийн хамтарсан сургуульд багшаар томилсон Энэтхэгийн засгийн газарт бид чин сэтгэлээсээ талархаж байна. Гадаад сурагчдад хэл зааснаараа ангид хамтач уур амьсгалыг бий болгох, идэвхтэй үйл ажиллагаанд чиглэсэн шинэ арга зүйд бид суралцлаа. Ийнхүү бид Монгол оронтой илүү ойр дотно харилцаатай болсон бөгөөд багш бүр өөрсдийн багшлах ур чадвараа бүтээлчээр хөгжүүлсэн таатай он жилүүдийг үдлээ.

MY IMPRESSIONS ON THE MONGOLIAN CHILDREN

*by Ms Chitra Hunt
Mongolia- India Joint School*

I have been working in Mongolia-India Joint School for 4 years as an English teacher the Indian government deputed 3 Indian teachers (Ms Chitra Hunt, Mr. R.S. Nathan and Dr. Reddy) for English and Mr. M. Srinivasan for Mathematics to teach the students of the Mongolia India Joint School from September 2003 to date. Mr. Biswal, from Education Consultancy India Ltd., is the Computer teacher. We are a team of 4 teachers from our parent organization, the Kendriya Vidyalaya Sangathan which has its Headquarters at New Delhi, India. Our primary goal is to make the Mongolian students proficient in English, Mathematics and Computer Technology.

Grades 8 to 11 have been divided into two groups for English (Elementary and Advanced). This facilitates teachers to give individual attention to students. The students are proficient in Grammar but lack fluency in communicating in English. Constant practice and encouragement by the teachers is needed for the students to be proficient in speaking. The students have improved considerably in their listening, speaking, reading and writing skills in English. They have grasped the semantics of the language but need to relate to daily activities in English. By organizing "Open Day" English Olympiads, English fortnight and other competitions, the school has encouraged and given opportunities to all students to participate and use the English language with fewer inhibitions. The students have learnt terminologies of Mathematics in English and are now able to understand and solve problems in English. Students are learning new trends in Computer technology.

The interaction and cooperation between Mongolians students and Indian teachers have been growing steadily and now a good rapport has been created. This enhances the teaching process, making it more effective and productive. These four years have been the most fulfilling and challenging of our careers. Lessons, using the interactive approach; and visual and audio aids generate interest in the language classes. The students are receptive and actively participate in classroom activities. The cooperation and friendly attitude of the school administration have encouraged us to work efficiently. The Mongolian students have a keen sense of creativity and skill in creating innovative, beautifully designed charts. They work well in groups and teams because they have a competitive spirit which encourages each student to give his best to reach the desired goals. The cultural exchanges between India and Mongolia have been fostered by students' enthusiastic participation in cultural events organized by the school and inter school competitions. This has created an awareness and appreciation of the cultural differences between the two countries. Several students, who go to University from our school are now interested in continuing their Higher studies in India which offers a wider range of subjects and opportunities to Mongolian students.

We are truly grateful to the Indian Government for deputing us as teachers to Mongolia-India Joint School. We have learnt new methodology and activity- oriented projects to create a communicative approach in classroom teaching which is beneficial in teaching a language to foreign students who do not think in that language. This enables students to be less self- conscious and introverted. We have developed close links to Mongolia and its people in this span of 4 years and will cherish these years as the most fulfilling, challenging and productive ones of our teaching careers.